



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 05 сарын 23 өдөр

Дугаар 168

Мандалговь


Хөрөнгө данснаас хасаж  
дахин үнэлэн бүртгэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 заалт, Монгол улсын Сангийн сайдын 2009 оны 135 дугаар тушаал, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 3 дугаар зүйлийн 3.1“а” заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Байгаль орчны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй автомашины гражыг данс бүртгэл эс хасч Орон нутгийн өмчийн албанд шилжүүлэх, бүртгэлгүй байсан 72 м<sup>2</sup> талбайтай автомашины гражийг 6'468'000 /зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга/ төгрөгөөр үнэлэн бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Үндсэн хөрөнгийг зохих журмын дагуу данс бүртгэлээс хасахыг аймгийн Байгаль орчны газрын дарга Н.Гантулга, байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэж авахыг аймгийн ОНӨА-ны дарга П.Очирбат нарт тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд үяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.



0100354